



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2025 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/160

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Нийслэлийн 2025 оны “Төсөв батлах тухай” 25/106 дугаар тушаал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх орон сууцны хороолол, хотхоны бохир ус татан зайлуулах ариутгах татуургын ф300мм-н голчтой 840 уртааш метр шугамын гэмтлийг тодорхойлох, угаалга хийх, дуран оношилгоо хийх төсөл, арга хэмжээг байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ (Ц.Төрхүү)-аар гүйцэтгүүлж батлагдсан төсвийн хүрээнд гэрээ байгуулж холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнаж хяналт тавьж ажиллахыг Хотын инженерийн дэд бүтцийн газрын дарга (Л.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

2. Санхүүжилтэд шаардагдах 6,276,742.00 (Зургаан сая хоёр зуун далан зургаан мянга долоон зуун дөчин хоёр) төгрөгийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний зардал”-аас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Б.Халиун)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн газрын дарга (Н.Отгонбаяр)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Г.БАТЗОРИГ



१. भिन्नता

מס' ארבע מאות ושלשים ושש